



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/63

Баян-Өндөр сум

Тохиолдол удирдлагын тогтолцоог идэвхжүүлэх
тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, 12.1.5, 13 дугаар зүйлийн 13.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, 34.2.3, Монгол Улсын Шадар сайдын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” 28 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Журам заавар шинэчлэн батлах тухай” А/328 дугаар, 2018 оны “Халдварт өвчний тохиолдлыг тандах журам батлах тухай” А/527 дугаар тушаал, Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны “Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн албыг шинэчлэн батлах тухай” А/84 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2025 оны 07 дугаар сарын 16-ны өдөр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын харьяа “Найрамдлын эрдэнэс” хүүхдийн зусланд амрагсад, ажилчдаас хоол хүнсээр дамжих өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэй үнэлэгдсэн тул ЭМГ-ын даргын 2024 онд баталсан А/64 дүгээр тушаалын дагуу тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэн, хариу арга хэмжээг зохион байгуулах шуурхай удирдлагын багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хоолны хордлогот халдварын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хоол хүнсээр дамжих өвчний үед ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын байцаагч /Б.Будсүрэн/-д даалгасугай.
3. Хоол хүнсээр дамжих өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, үнэн бодит, мэдээ мэдээллийг олон нийтэд түгээж ажиллахыг олон нийттэй харилцах ажилтан /Б.Лхагвадэмбэрэл/-д үүрэг болгосугай.

4. Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үеийн авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнан ажиллахыг Яаралтай гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Оюуномин/-д даалгасугай.
5. Хариу арга хэмжээнд ажилласан албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох, оношилгоо, эмчилгээнд шаардагдах зардлыг тооцохыг Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал Ц.Наран-Эрдэнэ нарт даалгасугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Уртнасан/-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ



Шуурхай удирдлагын багийн бүрэлдэхүүн

Багийн дарга:	Нийгмийн эрүүл мэндийн төвийн ахлах мэргэжилтэн
Багийн дэд дарга:	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн
Багийн нарийн бичиг:	Бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдолын вирусынх халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн

№	Албан үүрэг	Албан тушаал
1.ТӨЛӨВЛӨЛТ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАГ		
1	Багийн ахлагч	Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
2	Багийн гишүүн	Нийгмийн эрүүл мэндийн төвийн ахлах мэргэжилтэн
3	Багийн гишүүн	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, ахмад настны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
4	Багийн гишүүн	Сувилахуй болон хөнгөвчлөх, тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
2.ТАНДАЛТ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГ		
1	Багийн ахлагч	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч
2	Багийн гишүүн	Дархлаажуулалт,зоонозын халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн
3	Багийн гишүүн	Эмнэлгийн дотоод халдвар хариуцсан мэргэжилтэн
4	Багийн гишүүн	Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээ,хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн
5	Багийн гишүүн	Халдварт бус өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн
6	Багийн гишүүн	Хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
7	Багийн гишүүн	Дархлаажуулалтын бага эмч
3. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГ		
1	Багийн ахлагч	Яаралтай гамшгийн үеийн тусламж үйлчилгээ, оношилгоо эмчилгээний технологи хариуцсан мэргэжилтэн
2	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчийлгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
3	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчийлгээний төвийн чанарын албаны дарга

4	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчийлгээний төвийн халдвар судлаач
5	Багийн гишүүн	Эрдэнэт сувиллын цогцолборын эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
6	Багийн гишүүн	Эрдэнэт сувиллын цогцолборын чанарын албаны дарга
7	Багийн гишүүн	Эрдэнэт сувиллын цогцолборын халдвар судлаач
4. СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БАГ		
1	Багийн ахлагч	Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан
2	Багийн гишүүн	Хүүхэд, гэр бүл хөгжил, хүүхэд хамгааллын газрын Сэтгэл зүйч, нийгмийн ажилтан 1
3	Багийн гишүүн	Хүүхэд, гэр бүл хөгжил, хүүхэд хамгааллын газрын Сэтгэл зүйч, нийгмийн ажилтан 1
5. САНХҮҮ, НӨӨЦ ХАНГАЛТЫН БАГ		
1	Багийн ахлагч	Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
2	Багийн гишүүн	Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан
3	Багийн гишүүн	Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн
4	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Санхүү бүртгэлийн албаны дарга
5	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмзүйн тасгийн эрхлэгч
6	Багийн гишүүн	Эрдэнэт сувиллын цогцолборын Санхүүгийн албаны дарга
6. АНХАН ШАТНЫ ХЯНАЛТЫН БАГ		
1	Багийн ахлагч	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, ахмад настны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
2	Багийн гишүүд	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар
7. ЭРСДЭЛИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ БАГ		
1	Багийн ахлагч	Олон нийттэй харилах ажилтан
2	Багийн гишүүн	Орчны эрүүл мэнд, нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
3	Багийн гишүүн	Зураглаач, эвлүүлэгч
4	Багийн гишүүн	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сургалт, эрдэм шинжилгээний албаны дарга



Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 07 сарын 18 өдрийн
183-р тушаалын 2 хавсралт

ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Орхон аймаг

2025.07.17

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах байгууллагууд
1.Бэлэн байдлыг хангах				
1	Шуурхай удирдлагын багийг томилж, мэргэжил арга зүйгээр хангах	2025.07.17	Б.Будсүрэн	ЭМГ, БОЭТ
2	Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай үед дуудагдах албан хаагчдын судалгаа гаргах	2025.07.16	БОЭТ	ЭМГ, БОЭТ, ЭСЦ
3	Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоог төхөөрөмж, урвалж оношлуурыг бэлтгэх	2025.07.16	БОЭТ	ЭМГ, БОЭТ, ЭСЦ
2.Төлөвлөлт, эрсдэлийн үнэлгээ				
5	Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийж, тайлагнах	2025.07.17	Төлөвлөлтийн баг	
6	Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт хийхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг мэргэжлийн болон холбогдох байгууллагаас авч, мэдээллийн сан бүрдүүлэх	2025.07.17	Эрсдэлийн харилцаа холбоо, Эмнэлгийн тусламж үйлчилгээний баг	БОЭТ, ЭСЦ
7	Эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний асуумж боловсруулж, үнэлгээний дүнг танилцуулж авч хэрэгжүүлэх арга хэмжээг	2025.07.17	Төлөвлөлтийн баг	ЭМГ

	төлөвлөх				
	Хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө боловсруулж батлуулах, тохиолдол удирдлагын тогтолцооны хурлаар хэлэлцэх	2025.07.17	Төлөвлөлтийн баг	ЭМГ, БОЭТ, ЭСЦ	
	Хариу арга хэмжээний явц, үр дүнг тогтмол хянах, тайлагнах	Тухай бүр	ЭМГ	БОЭТ, ЭСЦ	
3. Тандалт, судалгаа					
1	Голомтыг тогтоох, хавьтлыг илрүүлэх, мэдээлэх, тандалт судалгааг хийх	2025.07.17-22	Тандалт судалгааны баг	БОЭТ, Найрамдлын эрдэнэс зуслан	
2	Тусгаарлах арга хэмжээг зохион байгуулах, төлөвлөх	2025.07.17	ЭМГ	БОЭТ, ЭСЦ, Найрамдлын эрдэнэс зуслан	
3	Өдөр тутмын өвчлөлийн мэдээ тайланд боловсруулалт хийж, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээний явц, үр дүнг тогтмол хянах	Тухай бүр	Тандалт судалгааны баг	ХӨСҮТ	
4	Мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, зөвлөмж боловсруулах	Тухай бүр	Тандалт судалгааны баг	ХӨСҮТ	
4. Эмнэлгийн тусламж үйлчилгээ					
	Төлөвлөлтийн багийг өдөр тутмын мэдээлэлээр хангах, бие бүрэлдэхүүн, багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, техникийн хүчин чадал, тусламж үйлчилгээний ачаалал эрсдлийг тооцон мэдээ мэдээллээр ТУТ-ын удирдлага, бусад багийг хангаж ажиллах	Тухай бүр	Эмнэлгийн тусламж үйлчилгээний баг	БОЭТ, ЭСЦ, Найрамдлын эрдэнэс зуслан	

	Голомтод эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, эмнэлэг хүртэлх тусламж үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Тухай бүр	БОЭТ	ЭМГ
	Шилжүүлэхэд шаардлагатай тусламж үзүүлэх Эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангуулах мэдээлэл хүргэх,	2025.07.17	ЭМГ	БОЭТ
	Тусгаарлан, хэвтүүлэн эмчлэх шаардлагатай иргэдийг аюулгүй тээвэрлэж хүргэх	2025.07.17	Найрамдлын эрдэнэс зуслан	ЭМГ, БОЭТ, ЭСЦ
	Тусгаарлан, хэвтүүлэн эмчлэх шаардлагатай иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх	2025.07.17-21	БОЭТ, ЭСЦ	ЭМГ
	Хариу арга хэмжээнд ашиглагдах хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, техник, багаж хэрэгслийн нөөцийн судалгаа гаргах, бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, нөхөн сэлбэх	Тухай бүр	БОЭТ, ЭСЦ	ЭМГ, Эрдэнэт ТӨҮГ
	Тусламж үйлчилгээ үзүүлсэн мэдээллийг нэгтгэх, мэдээлэх,	Тухай бүр	Эмнэлгийн тусламж үйлчилгээний баг	БОЭТ, ЭСЦ
	Сэтгэлзүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн байдалд үнэлгээ хийх	2025.07.18-19	Сэтгэл зүйн тусламж үйлчилгээний баг	ЭМГ, ХГБХХГ
	Сэтгэлзүйн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл хүргэх	2025.07.18-21	Сэтгэл зүйн тусламж үйлчилгээний баг	ЭМГ, ХГБХХГ
5.Эрсдэлийн харилцаа холбоо				
	Бие бүрэлдэхүүнд зарлан мэдээллэх, голомтод бүх төрлийн холбоог зохион	2025.07.17	Эрсдэлийн харилцаа	БОЭТ

	байгуулах,			холбооны баг	
	Дээд шатны байгууллагад нөхцөл байдлын мэдээг дамжуулах, хүлээн авах, холбооны тасралтгүй ажиллагааг хангах,	Тухай бүр		Эрсдэлийн харилцаа холбоо, эмнэлгийн тусламж үйлчилгээний баг	ОБГ, ХӨСҮТ
	Олон нийтийн цахим сүлжээнд цацагдаж байгаа мэдээ мэдээллийг шүүх, тандалт хийж, хариу арга хэмжээ авах болон шаардлагатай мэдээллийг удирдлагад танилцуулах	Тухай бүр		Эрсдэлийн харилцаа холбооны баг	ЭМГ
6. Урьдчилан сэргийлэлт, мэдээлэл, сургалт, сурталчилгаа					
	Зуслангийн ажилчдад хоол боловсруулах, эрүүл ахуйн сургалт хийх	2025.07.31-ний дотор		Найрамдлын эрдэнэс зуслан	ЭМГ
	Иргэд, эцэг эхчүүдэд урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргэх	2025.07.18-25		ЭМГ	Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд
	Өдөр тутмын үйл ажиллагааны шинэчилсэн мэдээллийг бэлтгэх, цахим хуудас, фейсбүүк хуудсаар дамжуулан хүн	Тухай бүр		ЭМГ	Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд